

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРААС  
2019 ОНЫ 09 ДҮГЭЭР САРД ХЭРЭГЖҮҮЛСЭН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2019 оны 09 дүгээр сарын 30

Улаанбаатар хот


Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гадаадын болон өөрийн орны иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч 2019 оны 09 дүгээр сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

1.1. Виз, зөвшөөрөл, харьяатын чиглэлээр:

Тайлант хугацаанд Монгол Улсад оршин суух үнэмлэх 2893 ширхгийг шинээр хэвлэн, 1331 ширхэг үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгаж, 169 ширхэг үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийн, гадаадын зургаан иргэнд регистрийн дугаар олгосон байна. Үйлчилгээний танхимаар 2100 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэжээ.

Нийт 4438 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгснөөс 1800-1882 дугаарын утсаар 1744, 7585-1882 дугаарын утсаар 114, биечлэн 662, автомат хариулагчаар 1918 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Мөн Хонконг, Оросын Холбооны Улсын Кызыл, Япон Улсын Токио хот дахь консулын ажилтанд утсаар виз, бүртгэлийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө, 11 улсын гадаадын 13 иргэнд цахим шуудангаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан байна.



Цахим визийн зөвшөөрлийн хүрээнд олон улсын хилийн боомт дээр “J” ангиллын 312, “S” ангиллын 402, “B” ангиллын нэг болон хоёр удаагийн орох 340, “B” ангиллын олон удаагийн гарах-орох 160 визийн зөвшөөрөл олгож, нийт давхардсан тоогоор 417 аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч хянан, 292 аж ахуйн нэгж, байгууллагын гадаадын 1214 иргэний визийн зөвшөөрлийн хүсэлтийг холбогдох хууль, журмын дагуу хянан цахимаар шийдвэрлэжээ.

Үндэсний хөгжлийн газрын дэргэдэх хөрөнгө оруулагчдад төрийн үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төвд тус байгууллагын хоёр мэргэжилтэн ажиллаж 83 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, гадаадын 44 иргэнд визийн зөвшөөрөл, 75 иргэнд оршин суух зөвшөөрөл олгож, 109 иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунган, 27 иргэний ангиллыг сольж, 34 иргэнд хасалт хийсэн байна. Мөн хөрөнгө оруулагчаар оршин суух зөвшөөрөлтэй 194 иргэнд зохих ангиллын виз олголоо.

2019 оны 09 дүгээр сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 66.1 хувиар, виз олголт 11.5 хувиар, оршин суух зөвшөөрөл олголт 9.3 хувиар, оршин суух зөвшөөрлийн хасалт 10.2 хувиар, түр ирэгчийн бүртгэл 19.7 хувиар, түр ирэгчийн хасалт 16.5 хувиар өссөн, харин хувийн урилга олголт 27.8 хувиар, оршин суух зөвшөөрөл сунгалт 18.8 хувиар тус тус буурсан байна.


Иргэний харьяалал, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын чиглэлээр:

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан нэг иргэн, харьяалалгүй нэг хүний хүсэлтэд холбогдох байгууллагуудаас санал авч дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулснаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлээ.

Монгол Улсын харьяатаас гарч гадаадын гурван улсын харьяат болох хүсэлт гаргасан 15 иргэний хүсэлтийг шинээр хүлээн авч, гадаадын зургаан улсын харьяат болох хүсэлт гаргасан 18 иргэний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авах ажиллагааг хийсэн. Мөн гадаадын таван улсын харьяат болох хүсэлт гаргасан 63 иргэний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авч дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, дөрвөн улсын харьяат болох хүсэлт гаргасан 44 иргэний хүсэлтийг Ерөнхий сайдад танилцуулснаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэв.

Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан харьяалалгүй хоёр хүний хүсэлтийг шинээр хүлээн авч, холбогдох байгууллагаас санал авах ажиллагааг хийсэн байна.

Иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан харьяалалгүй найман хүний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авч дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, гурван хүний хүсэлтэд холбогдох байгууллагуудаас санал авч дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулснаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлээ.



Хоёрдмол харьяалал үүсгэсэн 36 иргэнийг шинээр бүртгэж мэдээллийн санд оруулсан ба нийт 3430 иргэн бүртгэлтэй байна.

Мэргэжлийн зөвлөлийн хурлаар олон улсын болон гадаад улсын зургаан төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын асуудлыг хэлэлцэн дөрвөн төрийн бус байгууллагын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгаж, нэг байгууллагын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгон, нэг байгууллагын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлтийг түр түдгэлзүүлсэн байна. Түүнчлэн дээрх хугацаанд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргасан гурван төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын хүсэлтийг хүлээн авсан. 2019 оны 09 дүгээр сарын байдлаар тус байгууллагад бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй 94 төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газар байна.


#### 1.2. Хяналт шалгалт, албадан гаргах ажиллагааны чиглэлээр:

Тайлант хугацаанд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн таван улсын 82 иргэнийг байгууллагын даргын 17 удаагийн тушаалаар тус улсаас албадан гаргасан ба мэдээллийг холбогдох газруудад албан бичгээр хүргүүлэх ажлыг зохион байгуулав.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр байгууллагын даргын гурван удаагийн тушаалаар гадаадын гурван улсын гурван иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлж, гурван удаагийн тушаалаар гадаадын хоёр улсын дөрвөн иргэний хилээр нэвтрэх эрхийг сэргээн ажиллалаа.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.6 дугаар зүйлд зааснаар 210 зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн ба Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд заасан үндэслэлээр дөрвөн улсын 23 иргэнд гарах сануулга өгч, Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүгчийн нэг захирамжаар гадаадын нэг улсын хоёр иргэнийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төвийн байранд саатуулсан.

Тайлант хугацаанд есөн удаагийн төлөвлөгөөт, 15 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 238 аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын 4748 иргэнийг хамруулсан ба 380 гадаадын иргэн, 147 аж ахуйн нэгж, байгууллага /гадаадын 381 иргэн/, нэг уригч иргэн /гадаадын нэг иргэн/-д Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулж, 157,910,000 /нэг зуун тавин долоон сая есөн зуун арван мянга/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүллээ.



2019 оны 09 дүгээр сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан гадаадын иргэн 75.1 хувиар, уригч хуулийн этгээд 15.7 хувиар, албадан гаргагдсан гадаадын иргэн 57.7 хувиар, гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн 3 дахин тус тус өссөн, харин зөрчил гаргасан уригч иргэн 83.3 хувиар буурсан байна.

## ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, дотоод ажил, хүний нөөц, сургалт, олон нийттэй харилцах чиглэлээр:

“Хил хяналтын байгууллагын ажлын уялдаа холбоог хангах тухай”, “Хилийн боомтыг шилжүүлэх тухай”, “Агаарын замын боомтын асуудлаар авах арга хэмжээний тухай” Хилийн боомтын үндэсний зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн зөвлөмж, тогтоолын хэрэгжилт, байгууллагын дэргэдэх хүүхдийн цэцэрлэг байгуулсан тухай товч танилцуулгыг Хууль зүй, дотоод хэргийн сайдад, Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний гуравдугаар улирлын хэрэгжилт, Засгийн газрын 2019 оны “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил болгох тухай” 23 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргад, байгууллагын 2019 оны 08 дугаар сарын үйл ажиллагааны тоон мэдээг инфографик хэлбэрээр гарган Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргад, байгууллагын 2019 оны 08 дугаар сарын ажиллагааны тайланг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргад, Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд нийслэлийн нутаг дэвсгэрт гадаадын иргэдийг гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх талаар тус байгууллагын хийж гүйцэтгэсэн ажлын тайланг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тус тус албан бичгээр хүргүүлэн ажиллалаа.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 73 дугаар тушаалын дагуу зохион байгуулагдсан Хууль зүй, дотоод хэргийн салбарын агентлаг, байгууллагуудын нээлттэй өдөрлөгт байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэг, үйл ажиллагаа, шинээр нэвтрүүлж буй үйлчилгээг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулсан.

Төв болон орон нутаг дахь газарт нийт 63 өргөдөл, хоёр гомдол ирснийг хүлээн авч, бүртгэлжүүлэн харьяалах газар, хэлтэст нь шилжүүлснээс 54 өргөдөл, хоёр гомдол шийдвэрлэгдэж, есөн өргөдөл хуульд заасан хугацааны хүрээнд шийдвэрлэлтийн шатандаа байгаа ба хугацаа хэтэрсэн өргөдөл байхгүй.

Байгууллагын архивт хадгалагдаж байгаа байнга хадгалах 401 хадгаламжийн нэгжийг Үндэсний төв архивт хүлээлгэн өгсөн.

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран “Гадаадын иргэн, харьяатын газрын удирдах албан

тушаалтан, хяналтын улсын байцаагчдын сургалт, зөвлөгөөн"-ийг Өмнөговь аймгийн Өмнөд бүс дэх газарт зохион байгууллаа.

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 08 дугаар сарын "Зөвшөөрөл олгох тухай" 57 дугаар тогтоолыг тус тус үндэслэн төрийн захиргааны 52 албан тушаалын тодорхойлолт, Хөдөлмөрийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3.2-т заасныг үндэслэн төрийн үйлчилгээний 32 албан тушаалын ажлын байрны тодорхойлолтыг тус тус байгууллагын даргын тушаалаар батлан, албан хаагч нэг бүрд танилцуулан ажиллалаа.

Мөн төрийн алба хаасан хугацаа 16 жилд хүрсэн гурван албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинэчилсэн тогтоосон.

Улс тунхагласны баярын өдрийг тохиолдуулан төрийн дээд одон, медаль болон салбарын шагналд тус байгууллагаас олон жил үр бүтээлтэй ажиллаж, эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан 12 албан хаагчийн холбогдох материалыг бэлтгэж Хууль зүй, дотоод хэргийн яамд хүргүүлэв.

Удирдлагын академиас зохион байгуулсан "Манлайлал ба хөгжил", "Төрийн албаны сургалтын шинэ тогтолцоо, сургалтыг төлөвлөх, зохион байгуулах" сэдэвт сургалт, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас "Дижитал хөгжилд хамтдаа" сэдэвт форумд тус тус нэг албан хаагч хамрагдлаа. Тайлант хугацаанд хоёр албан хаагчийг богино хугацааны сургалтад хамруулж, хоёр албан хаагчийг байгууллагын захиалгаар урт хугацааны сургалтад хамруулахаар боллоо.

Байгууллагын албан хаагчдад зориулан Мэдээлэл сэтгүүлийн 2019 оны гуравдугаар улирлын хэвлэлд "Байгууллагын болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, загвар, аргачлал" сэдвээр эх бэлтгэлийг бэлтгэн, 100 хувийг хэвлүүлж албан хаагчдад судлуулав.

Тайлант хугацаанд "Улаанбаатар хотын Захирагч С.Амарсайхан Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцлаа", "Хууль зүй, дотоод хэргийн салбарын агентлаг, байгууллагууд Сүхбаатарын талбайд нээлттэй үйлчиллээ", "Гадаадын иргэн, харьяатын газар дэргэдэх 100 хүүхдийн цэцэрлэг өнөөдөр нээлтээ хийлээ", "Замын-Үүд боомтын үйл ажиллагааг 09 дүгээр сарын 01-ний өдрөөс түр горимд шилжүүллээ", "'А" болон "S" ангиллын визийн зөвшөөрлийг гадаадын иргэнд цахимаар олгоно", "БНСУ-д зорчих визний журамд өөрчлөлт орлоо" зэрэг 12 мэдээ, гадаадын иргэдийн бүртгэлийн журамтай холбоотой нэг ярилцлага, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж байгууллагын холбогдох хууль тогтоомжийг сурталчилсан дөрвөн видео санамж мэдээллийг дохионы хэлээр орчуулан тус тус байгууллагын болон мэдээллийн цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажиллалаа.

## 2.2. Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах Ажлын хэсгийн хуралд байгууллагын дарга болон хуулийн ахлах мэргэжилтэн оролцож, хурлаас гарсан шийдвэрийн дагуу санал бэлтгэн Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын даргад, Зам, тээврийн хөгжлийн яамнаас боловсруулсан "Олон улсын нисэх буудлын ашиглалтын талаар авах

зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд санал бэлтгэн Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргад, Терроризмтой тэмцэх салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөлд санал бэлтгэн Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөлийн Нарийн бичгийн даргад тус тус албан бичгээр хүргүүлсэн болно.

Тайваний Тайпэй хотноо 2019 оны 09 дүгээр сарын 25-аас 29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Хилийн менежмент олон улсын семинар” болон “Виз хуурамчаар үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажлын тайлан” сэдэвт хуралд тус байгууллагын хоёр албан хаагчийг оролцуулах ажлыг зохион байгууллаа.

Байгууллагын дарга тэргүүтэй төлөөлөгчид Бүгд Найрамдах Солонгос Улсаас Монгол Улсад суугаа Элчин Сайдын Яамны Дэд Консул Кил Кан Мугийг байгууллага дээрээ хүлээн авч уулзан, хамтын ажиллагааны талаар санал солилцов.

### 2.3. Мэдээллийн технологийн чиглэлээр:

Байгууллагын дэргэдэх хүүхдийн цэцэрлэгт 10 ширхэг хяналтын камер, хянах дэлгэцийг суурилуулж ажиллагаанд оруулснаар эцэг эхчүүд хүүхдэдээ хяналт тавих боломжийг бүрдүүлж өглөө.

### 2.4. Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн чиглэлээр:

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын багцад Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу 2019 онд 6,27 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд өссөн дүнгээр 09 дүгээр сард 4,96 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсоноос 4,28 тэрбум төгрөгийг зохих дүрэм, журмын дагуу анхан шатны баримтыг үндэслэн зарцуулсан

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Засгийн газрын 2003 оны 172 дугаар тогтоолын дагуу 09 дүгээр сарын байдлаар 4 тэрбум 357 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлого, 933,5 сая төгрөгийн хүү торгуулийн орлого, 74,9 сая төгрөгийн визийн хуудасны орлогыг улсын төсөвт төвлөрүүллээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020-2022 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан төсвийн төсөөллийг боловсруулж, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3-т заасны дагуу Сангийн яаманд танилцуулж хянуулсан.

Байгууллагын архивын гурван өрөөг засварлахтай холбогдуулан тохижилт үйлчилгээнд 1,5 сая төгрөг зарцуулсан байна.

### 2.5. Хяналт шинжилгээ, аудитын чиглэлээр:

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны 2019 оны 08 дугаар сарын мэдээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Ерөнхий сайдын ажлын албанд, мөн сарын статистик мэдээг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт тус тус хүргүүлсэн.

Байгууллагын даргын баталсан удирдамжийн дагуу Өмнөговь аймгийн Өмнөд бүс дэх газарт дотоод аудитын хяналт шалгалтыг зохион байгуулж, тус

шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах талаар холбогдох зөвлөмжийг хүргүүллээ.

#### 2.6. Хилийн боомт, орон нутгийн чиглэлээр:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолд заасны дагуу гадаадын 42 иргэнийг орох чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаасан ба зохих бичиг баримтын бүрдэл хангаагүй гадаадын 18 иргэнийг гарах чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаасан.

Монгол Улсаас хилийн чанадад суугаа Элчин сайдын яам, консулын газар, өргөмжит консулаас визийн хүчинтэй хугацаа, нэр, огноо буруу, визийн зориулалт бичигдээгүй зэрэг гадаадын 273 иргэнд олгогдсон визийг тухай бүр хуулбарлан авч, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолын дагуу визийг дахин олгон хил нэвтрүүлсэн болно.

Үйл ажиллагаа явуулж буй хилийн 14 боомтод ажлын өдрийн 09:00, 16:00 цагуудад хил нэвтрэлт, онцлог нөхцөл, удирдлагын үүрэг, даалгаврыг нийт 34 удаа авч, бүртгэлийн дэвтэрт хөтлөн ажиллалаа.

“Хөгжлийн Хөтөч-Дэд бүтэц” төслөөс зохион байгуулагдсан Цагаандэл уул-Өлзий боомтын хилийн боомтыг ижил түвшинд төлөвлөх, хөрөнгө оруулалтын хэмжээг тохиролцох, бүтээн байгуулалтыг зэрэг эхлүүлэх ажлын нэгдсэн төлөвлөгөө гаргах, дээрх ажлын хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийн хуралдаанд байгууллагыг төлөөлж Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтсийн дарга оролцов.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР